



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/226.

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 38 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Батширээт, Биндэр сумдын нутагт орших "Гутайн" даваа ашигт малтмалын орд газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

-аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

-аймгийн Мэргэжлийн хяналтын газрын геологи,  
уул уурхайн хяналтын улсын байцаагч  
-аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
уул уурхай, тусгай хамгаалалт хариуцсан  
мэргэжилтэн  
-аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн  
төлөөлөгч

2. Хяналт шалгалтын удирдамжийг батлуулан, хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011052